


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

02.24 - 02.28



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт COVID-19-ийн тархалттай холбоотой АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд сүүлийн 10 жилийн хамгийн их уналт үзүүлсэн ба бүх томоохон индексүүд "correction" буюу 10%-аас их уналт үзүүллээ.

S&P 500 индексийн сагсанд багтах бүх салбарын компаниуд уналттай байсан ба эрчим хүчний компаниудын хувьцаа газрын тосны ханш буурсантай холбоотой хамгийн их уналттай байлаа. Харин S&P 500 индексэд багтах Netflix компанийн хувьцааны ханш тогтвортой байсантай холбоотой харилцаа холбооны салбар хамгийн сайн үзүүлэлттэй байлаа. Cboe Volatility Index (VIX) Баасан гарагт 50 хүртэл өссөн ба энэ нь 2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойших хамгийн өндөр үзүүлэлт болсон байна. Хувьцааны арилжаа Пүрэв гарагт өнгөрөгч 1 жилийн хамгийн их хэмжээнд хүрсэн бол опционий арилжаа түүхэн дээд хэмжээндээ хүрсэн гэж Wall Street Journal мэдээллээ.

Европ: COVID-19-ийн хурдацтай тархалт дэлхийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй холбоотой Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд 2008 оны санхүүгийн хямралаас хойших хамгийн их уналттай хаагдлаа.

Итали улсад COVID-19-ийн тархалт Европын бусад улсуудтай харьцуулахад хамгийн хурдацтай байгаа ба Итали улсын эрх баригчид энэхүү тархалтыг хязгаарлахын тулд Хойд Венето болон Ломбарди бүсийн 11 хотод хорио цээр тогтоогоод байна. Европын үйлдвэрлэлийн салбаруудын гол нийлүүлэлтийг хийдэг энэхүү бүс нутгуудад COVID-19-өөс үүдэн 17 хүн нас барсан бол 655 хүн халдвар аваад байгаа юм. Итали улсын хөрөнгийн зах зээл 11%-аар буураад байгаа ба энэхүү бууралт нь хөрөнгө оруулагчид Итали улс 2020 оны 1-р улиралд хямралд орох эрсдэлтэй гэж үзэж байгаатай холбоотой.

Итали болон Франц улсад буй Европын төв банкны төлөөлөгчид засгийн газраас COVID-19-ийн тархалтын эдийн засагт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байгаа тул үүний эсрэг эдийн засгийг идэвхжүүлэх бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй гэж мэдэгдсэн байна.

Япон: Энэ долоо хоногт COVID-19-ийн тархалт дэлхийн эдийн засаг болон Япон улсын эдийн засагт үзүүлэх нөлөөтэй холбоотой Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байсан. Даваа гарагт Япон улсын эзэн хааны төрсөн өдөр байсантай холбоотой Япон улсын хөрөнгийн зах зээл хаалттай байлаа.

Вирус тархалтад Япон улс харьцангуй эмзэг байгаа ба 2-р сарын 27-ны өдөр Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага Япон улс халдварын тоогоор БНХАУ, Өмнө Солонгос болон Итали улсын араас бичигдэж байгаа гэж мэдээллээ.

БНХАУ: Дэлхийн бусад улс орнуудын COVID-19-ийн тархалт анхаарал татаж байгаатай холбоотой БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд бусад томоохон улс орнуудын индексүүдтэй харьцуулахад хамгийн бага уналттай байлаа.

Хэдийгээр бусад улс орнуудад вирус хурдацтай тархаж байгаа ч БНХАУ-д вирусийн тархалт хязгаарлагдаж байна. Шинэ халдварын тоо БНХАУ-д эрчимтэй буураж байгаа ба 20 бүс нутагт 6 хоног дараалан шинээр халдвар авсан хүн байхгүй байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,026.15	-0.71% ▼
Dow Jones	АНУ	25,409.36	-12.36% ▼
S&P 500	АНУ	2,954.22	-11.49% ▼
Nasdaq	АНУ	8,566.48	-10.55% ▼
S&P/TSX	Канад	16,263.05	-8.86% ▼
FTSE 100	Их Британи	6,580.61	-11.12% ▼
S&P/ASX 200	Австрали	6,441.20	-9.77% ▼
Nikkei 225	Япон	21,142.96	-9.59% ▼
Hang Seng	Хонг Конг	26,129.93	-4.32% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	111.18
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	100.76
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.01
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	106.56
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.69
DBM' 2023	USD	7.250%	106.66
TDBM' 2020	USD	9.375%	100.96
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.19

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.515	-0.10 ▼
Libor 3M	1.463	-0.17 ▼
Libor 6M	1.397	-0.23 ▼
Libor 1YR	1.382	-0.26 ▼
US 2YR Bond	0.765	-0.38 ▼
US 3YR Bond	0.759	-0.36 ▼
US 5YR Bond	0.816	-0.31 ▼
US 10YR Bond	1.053	-0.27 ▼

Валютын ханш	2020.02.28	Өөрчлөлт
USD	2,762.71	0.07% ▲
CNY	394.75	0.56% ▲
EUR	3,039.26	1.77% ▲
RUB	41.16	-4.06% ▼
KRW	2.28	0.00%
JPY	25.37	2.67% ▲
CAD	2,054.52	-1.37% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,585.69	-3.51% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	16.67	-9.87% ▼
Зэс	USD/lb.	254.00	-2.91% ▼
Нүүрс	USD/MT	66.80	-1.18% ▼
WTI газрын тос	USD/bbl.	44.76	-16.15% ▼
Brent газрын тос	USD/bbl.	50.52	-13.64% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. I	5.6%
Бодлогын хүү	2020. I	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. I	10.86 %
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. I	11.42%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. I	4.74%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. I	17.06%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. I	10.30%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 51 компанийн 78.4 сая төгрөгийн 3,584,421 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Материалимпекс” /MIE/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсөж 9,200.00 төгрөг хүрч хаагдсан бол “Говь” /GOV/ компанийн хувьцаа 5.36%-аар буурч 242.90 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

02-р сарын 28-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,747.1 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,026.15 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.71%-аар өссөн байна.



Зах зээлийн тойм

Арилжигдсан үнийн дүн	Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн	78.4
Зах зээлийн үнэлгээ	2,747,141.9

Зах зээлийн индексүүд

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,026.15	-0.71% ▼
MSE I индекс	9,376.36	-0.95% ▼
MSE II индекс	7,812.65	0.37% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа

Хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
АПУ	21,360	13,892,913
Монос хүнс	169,506	12,233,998
Ард санхүүгийн нэгдэл	7,666	11,527,168
Инвескор ББСБ	3,970	10,351,630
Говь	26,132	6,434,841

Өсөлттэй хувьцаа

Хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Материалимпекс	9,200.00	15.00% ▲
Би Ди Сек	900.00	5.88% ▲
Улсын их дэлгүүр	1,300.00	4.08% ▲
Баянгол зочид буудал	27,000.00	1.89% ▲
Хөвсгөл алтан дуулга	649.20	1.49% ▲

Бууралттай хувьцаа

Хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Говь	242.90	-5.36% ▼
Тандэм инвест ББСБ	25.01	-4.72% ▼
Айтүүлс	71.76	-3.70% ▼
Гермес центр	135.00	-3.57% ▼
Мандал даатгал	50.99	-3.04% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК

ҮЦК	Дүн (төг)
Ард Секюритиз	36,790,816
Райнос Эссэт Менежмент Монгол	18,273,254
Ти Ди Би Капитал	18,058,112
Би Ди Сек	14,008,706
Голомт Капитал	11,606,546

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	644.01	685,344
Таван толгой	6,610.00	348,117
МИК Холдинг	14,800.00	306,498
Говь	2,660.00	190,796
Инвескор ББСБ	242.90	189,489

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	NA	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	NA	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	NA	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	NA	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БҮК	2,465.3	526.2	21.3%	4.0	NA	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	NA	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	NA	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	NA	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	NA	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	NA	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	NA	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	NA	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	NA	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	NA	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
30	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ



Компанийн тухай хуулийн 83-р зүйлийн 83.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34-р зүйлийн 34.2.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 62-р тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 4-р тушаалыг тус тус үндэслэн шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээний хүрээнд компанийн ажилтнуудын ердийн ажлын цагийг 2020 оны 2-р сарын 21-ний өдрөөс эхлэн Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал цуцлагдах хүртэлх хугацаанд 1 цагаар богиносгож, 8:30-16:30 цаг хүртэл байхаар зохицуулж, ажлын тусгай горимд шилжүүлэхээр боллоо.

Энэхүү ажлын цагийн хуваарийн өөрчлөлт нь МХБ-ийн арилжааны цагийн хуваарьт нөлөөлөхгүй болно.

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

- “Сүү” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2-р сарын 17-ны өдрийн №02 тоот тогтоолоор 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаандаа 5 төгрөг, нийт 1.7 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар болов.
- “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 3-р сарын 28-ны өдрийн 12:00 цагт хуралдуулахаар товлон шийдвэрлэсэн боловч Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2-р сарын 19-ний өдрийн ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулахаар болсон байна.



БУСАД МЭДЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19-р зүйлийн 19.1 дэх хэсгийг үндэслэн мэдээлэх үүрэгтэй этгээдийн тус хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх, үүрэг хүлээсэн. Үүнтэй холбоотойгоор зайны хяналт болон газар дээрх шалгалтаар мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх мэдлэг дутмаг, хуулиар хүлээсэн үүрэг, түүний хэрэгжилт хангалтгүй, дотоод хяналтын хөтөлбөр нь эрсдэлийн үнэлгээнд үндэслэгдээгүй, бүрдүүлбэр дутуу, бэлэн мөнгөний болон сэжигтэй гүйлгээний тайланг Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанд хуулийн хугацаанд хүргүүлээгүй зэрэг алдаа дутагдлууд илэрсэн. Түүнчлэн, нэр бүхий банк бус санхүүгийн байгууллагууд өөрийн үйл ажиллагааны мөнгөн хөрөнгийн урсгалыг банканд дахь байгууллагын эзэмшлийн бус, иргэдийн хувийн дансаар явуулах тохиолдлууд илрээд байна.

Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлж буй үйл ажиллагаанд Компанийн тухай хуулийн 84-р зүйлд заасан эрх бүхий албан тушаалтан, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасны дагуу тухайн хоршооны гишүүн, түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн хувийн дансаар гүйлгээ хийхийг хориглосон тул зөвхөн банканд дахь тухайн хуулийн этгээдийн бүртгэлтэй харилцах дансаар дамжуулан гүйлгээ хийж байхыг мэдэгдье.

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

- Нүүрс, газрын тосны экспортыг 3-р сарын 15 хүртэл хойшлуулав.
- Хүнс тээвэрлэсэн автомашиныг зөвшөөрлийн дагуу нийслэл рүү нэвтрүүлж байна.
- Монголбанкны хяналтын зөвлөл хуралдлаа



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Шинэ төрлийн коронавирусийн тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосонтой холбоотой эдийн засгийг эрчимжүүлэх асуудлаар Засгийн газар хуралдлаа.

Хуралдаанд Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд оролцсон. Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн 3-р сарын сүүлээр төлөвлөж байсан Мөнгөний бодлогын хорооны хурлын товыг нааш татаж 3-р сарын эхээр хийхээр болсон тухай мэдээлсэн. Ингэхдээ одоо 11 хувьд байгаа Мөнгөний бодлогын хүүг бууруулах санал оруулна гэдгээ мэдэгдлээ. 12-р сард Монголбанк бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулах санал оруулж байсан ч хороо хэвээр үлдээгээд байсан юм. Мөнгөний бодлогын хүүг бууруулснаар зээлийн хүү буурч эдийн засгийг дэмжинэ гэж Төв банк үзжээ. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн эрч 2019 онд суларч 5.1 хувь руу буурсан ба инфляц сүүлийн саруудад төв банкны зорилтот түвшинээс 3 орчим нэгж хувиар доогуур байгаа юм.

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

УОК-ын энэ сарын 26-ны хуралдаанаар гуравдугаар сарын 2-ноос эхлэх байсан нүүрс, газрын тосны экспортыг гуравдугаар сарын 15 хүртэл хойшлууллаа.

Монголын хилээс 100 гаруй км-ийн цаана шинэ коронавирусний халдварын тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотой Гашуунсухайт, Шивээ хүрэн, Бичигт, Булган боомтоор хоёрдугаар сарын 10-наас гуравдугаар сарын 2-ныг хүртэл түүхий эд экспортлохыг хориглоод байсан юм. Экспортыг эхлүүлэх хугацааг сунгасныг УОК-ын дарга Ө.Энхтүвшин: "Тээвэрлэлтийг гуравдугаар сарын 2-ноос эхлүүлэх нөхцөл боломж хангагдаагүй гэж үзсэн" хэмээн тайлбарлав.



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.